



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

“Харгуй” төрийн өмчит хувьцаат
компанийн 2018 оны төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 618 дугаар тогтоолоор баталсан “Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр хавсралтаар өөрчлөн баталсугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 618 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2 дугаар хавсралтад заасан хөрөнгө оруулалтыг нэмсүгэй.

3. Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсонтой холбогдуулан компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

4.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Ч.Алтанзаяад даалгасугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН

ХЭЛТСИЙН ДАРГА

Б.Товас Б.ГАВАА

0002030




Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн
 318 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ХАРГУЙ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
 2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

| Д/д | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Х.нэгж | 2017 оны | | 2018 оны төлөвлөгөө | Төлөвлөгөө тодотгол | Харьцуулалт | |
|-----|--|---------|-------------|--------------|---------------------|---------------------|--------------------|--------------------|
| | | | Төлөвлөгөө | ХБГ үйцэтгэл | | | 2018 төл /2018 тод | 2018 тод- 2018 төл |
| 1 | Нийт орлого | мян.төг | 1,020,000.0 | 1,472,684.0 | 1,060,000.0 | 1,060,000.0 | 100.0 | - |
| 2 | Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил | мян.төг | 940,000.0 | 878,408.6 | 800,000.0 | 650,000.0 | 81.3 | (150,000.0) |
| | Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил | мян.төг | 50,000.0 | 581,740.5 | 200,000.0 | 350,000.0 | 175.0 | 150,000.0 |
| | Бусад орлого | мян.төг | 30,000.0 | 12,534.9 | 60,000.0 | 60,000.0 | 100.0 | - |
| 2 | Нийт зардал | мян.төг | 1,012,115.6 | 1,416,364.0 | 1,041,085.0 | 1,041,085.0 | 100.0 | - |
| | Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал | мян.төг | 196,594.0 | 194,386.1 | 179,371.0 | 179,371.0 | 100.0 | - |
| 3 | Татварын өмнөх ашиг /алдагдал/ | мян.төг | 7,884.4 | 56,320.0 | 18,915.0 | 18,915.0 | 100.0 | - |
| 4 | Цэвэр ашиг /алдагдал/ | мян.төг | 7,096.0 | 50,688.0 | 17,023.5 | 17,023.5 | 100.0 | - |
| 5 | Төсвийн нийт төлбөрт | мян.төг | 150,000.0 | 280,984.2 | 249,722.5 | 249,722.5 | 100.0 | - |
| 6 | Төрийн өмчийн ногдол ашиг | мян.төг | 1,419.2 | 10,137.6 | 3,404.7 | 3,404.7 | 100.0 | - |
| 7 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 59 | 59 | 56 | 56 | 100.0 | - |
| 8 | Нийт цалингийн сан | мян.төг | 357,210.4 | 411,234.1 | 400,000.0 | 400,000.0 | 100.0 | - |
| 9 | Нэг ажилтны дундаж цалин | мян.төг | 504.5 | 580.8 | 595.2 | 595.2 | 100.0 | - |
| 10 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | төг | 0.99 | 0.96 | 0.98 | 0.98 | 100.0 | - |
| 11 | Хөрөнгө оруулалт | мян.төг | - | - | 120,000.0 | 130,000.0 | 108.3 | 10,000.0 |
| 12 | Нийт авлага | мян.төг | 10,500.0 | 99,498.3 | 10,500.0 | 10,500.0 | 100.0 | - |
| | Үүнээс: Найдваргүй | мян.төг | - | - | - | - | - | - |
| 13 | Нийт өглөг | мян.төг | 1,500.0 | 1,000.0 | 1,500.0 | 1,500.0 | 100.0 | - |
| | Богино хугацаат өр төлбөр | мян.төг | 1,500.0 | 1,000.0 | 1,500.0 | 1,500.0 | 100.0 | - |
| | Урт хугацаат өр төлбөр | мян.төг | - | - | - | - | - | - |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны ~~04~~ дугаар сарын ~~03~~-ний өдрийн
~~31#~~ дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



"ХАРГУЙ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭХ АЖИЛ

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ (мян.төг) |
|--------------------------------------|--|-------------|------------|----------------|--------------------|
| 1 | Цэнхэрмандал сумын шуурхай ажлын хэсэгт худаг гаргах | ш | 1 | 10,000.0 | 10,000.0 |
| 2018 оны хөрөнгө оруулалтын нийт дүн | | | | | 130,000.0 |